

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/17/НА-СТА-ТХН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: В.Эрдэнэцогт  
Утас: 260512 Цахим хаяг: [erdenetsogtv.a@audit.gov.mn](mailto:erdenetsogtv.a@audit.gov.mn)  
Аудитор: Б.Долгоржав  
Утас: 99064808 Цахим хаяг: [dolgorjab@audit.gov.mn](mailto:dolgorjab@audit.gov.mn)  
Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг  
Утас: 99061771 Цахим хаяг: [info@imkaudit.mn](mailto:info@imkaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>12</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>17</b>
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>19</b>
5.1 Зөвлөмж.....	19
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>21</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний
ТӨОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.03 № 06/341  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ НЭГДСЭН  
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН  
Д.ОД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх AUS239885 төслийг 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 2022/455 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд байгуулсан бөгөөд 7,500.0 мянган еврогийн өртөгтэй 13.3 км цэвэр усны уян ширмэн хоолой солих, 15.0 мянган ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажлын төслийн гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Австри Улсын "Ти Ар Эм" ХХК, Төслийн туслан гүйцэтгэгчээр Монгол Улсын "Эм Ти Юу" ХХК ажиллаж байна.

Тайлант онд Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 2024 онд дуусах 7,500.0 мянган еврогийн AUS239885 дугаар гэрээг, нийт 3 удаа сунгасан ба 2025 оны 10 сарын 23-нд байгуулсан гэрээнд 2026 оны 3 сарын 31-нд дуусгахаар заасан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн хүрээнд 2025 онд уян ширмэн хоолой, холбох хэрэгсэл болон 2, 3 дугаар ээлжийн 10.0 мянган ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур, холбох хэрэгслийн захиалга, татан авалт, тээвэрлэлт бүрэн хийгдэж, төслийн талбайд нийлүүлсэн байна. Төслийн 3 дугаар ээлжийн 5000 ш цэвэр усны ухаалаг тоолуур, холбох хэрэгслийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр туслан гүйцэтгэгч Эм Ти Юу ХХК-аас ашиглагч Дархан-Ус суваг ХК-д актаар хүлээлгэн өгсөн байна.

Өмнөх оноос цэвэр усны олборлолт 52.5 м3 ус, цэвэр усны борлуулалтын орлого 157.1 м3 -аар өссөн байна.

## **Бусад асуудал**

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн Дархан хотын инженерийн дэд бүтцийг сайжруулан ус хангамжийн насжилт өндөртэй шугам хоолойг шинэчлэх ажлын гүйцэтгэл 100 хувь, усны зүй зохистой хэрэглээг дэмжих, Дархан хотын усны алдагдлыг бууруулан усны тоолууржилтын ухаалаг систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэл 71.5 хувь, инженер, техникийн ажиллагсдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн ус хэрэглээний боловсролыг дээшлүүлэх сургалтын ажлын гүйцэтгэл 100 хувь, нийт төслийн хэрэгжилт 90.5 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



*B. M*

Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,999,235,023.32</b>	<b>22,304,293,741.33</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,790,201.10</b>	-
35400	Хангамжийн материал	1,790,201.10	-
35440	Түлш, шатах тослох материал	1,790,201.10	-
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>19,997,444,822.22</b>	<b>22,304,293,741.33</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	19,997,444,822.22	22,304,293,741.33
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>66,720,739.44</b>	<b>50,741,802.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>66,720,739.44</b>	<b>50,741,802.12</b>
39200	Биет хөрөнгө	66,720,739.44	50,741,802.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,333,333.39)	(19,333,333.43)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	36,605,700.00	36,605,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,215,596.70)	(16,726,794.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,116,400.00	14,116,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,452,430.47)	(3,920,170.27)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>20,065,955,762.76</b>	<b>22,355,035,543.45</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>20,065,955,762.76</b>	<b>22,355,035,543.45</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>20,065,955,762.76</b>	<b>22,355,035,543.45</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	20,065,955,762.76	22,355,035,543.45
51210	Өмнөх үеийн үр дүн	5,106,492,229.39	20,065,955,762.76
51220	Тайлант үеийн үр дүн	14,959,463,533.37	2,289,079,780.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>20,065,955,762.76</b>	<b>22,355,035,543.45</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>15,526,197,182.00</b>	<b>2,940,038,919.11</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,968,804,982.00</b>	<b>2,940,038,919.11</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,968,804,982.00</b>	<b>2,306,848,919.11</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,968,804,982.00	2,306,848,919.11
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,968,804,982.00	2,306,848,919.11
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>633,190,000.00</b>
1221	Хандив тусламж /дотоод/	-	633,190,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	633,190,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	633,190,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>557,392,200.00</b>	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	557,392,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	557,392,200.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>566,733,648.63</b>	<b>650,959,138.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>566,733,648.63</b>	<b>650,959,138.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>535,181,791.35</b>	<b>636,915,339.37</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,642,000.00	416,220,322.00
210101	Үндсэн цалин	370,642,000.00	416,220,322.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,112,750.19	34,611,647.92
210201	Тэтгэврийн даатгалын зардал	27,657,060.19	21,500,535.04
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,706,420.00	4,162,203.22
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,667,840.00	2,865,022.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,172,590.00	553,080.65
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	5,908,840.00	5,530,806.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,959,500.00	45,960,000.00
210304	Байрны түрээс	44,959,500.00	45,960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,402,520.74	23,992,018.93
210401	Бичиг хэрэг	2,636,950.00	2,637,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,361,023.21	18,755,401.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	764,646.53	900,517.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,639,901.00	1,698,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,078,800.00	7,799,228.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,727,000.00	-
210604	Урсгал засвар	10,351,800.00	7,799,228.00
2107	Томилолт, зочны зардал	29,496,000.00	71,735,288.20
210701	Гадаад албан томилолт	-	14,992,888.20
210702	Дотоод албан томилолт	29,496,000.00	56,742,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,570,795.00	20,617,897.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,512,455.00	12,020,897.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	7,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	249,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	204,240.00	257,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,583,000.00	1,340,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,919,425.42	15,978,937.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,919,425.42	15,978,937.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,551,857.28</b>	<b>14,043,799.05</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	14,043,799.05
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	14,043,799.05
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,043,799.05
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	14,043,799.05
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,551,857.28	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,551,857.28	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>14,959,463,533.37</b>	<b>2,289,079,780.69</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>14,959,463,533.37</b>	<b>2,289,079,780.69</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>557,392,200.00</b>	<b>633,190,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>633,190,000.00</b>
122	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>633,190,000.00</b>
1221	Хандив тусламж /дотоод/	-	633,190,000.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	633,190,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	633,190,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	557,392,200.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	557,392,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	557,392,200.00	-
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>552,393,200.00</b>	<b>633,190,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>552,393,200.00</b>	<b>633,190,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>520,841,342.72</b>	<b>619,146,200.95</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,642,000.00	416,220,322.42
210101	Үндсэн цалин	370,642,000.00	416,220,322.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,112,750.19	34,611,647.50
210201	Тэтгэврийн даатгалын зардал	28,119,667.23	21,500,534.62
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	3,706,420.00	4,162,203.22
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,729,136.00	2,865,022.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	609,090.96	553,080.65
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	5,948,436.00	5,530,806.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,959,500.00	45,960,000.00
210304	Байрны түрээс	44,959,500.00	45,960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,981,497.53	22,201,817.83
210401	Бичиг хэрэг	2,636,950.00	2,637,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,940,000.00	16,965,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	764,646.53	900,517.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,639,901.00	1,698,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,380,300.00	7,799,228.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,967,000.00	-
210604	Урсгал засвар	9,413,300.00	7,799,228.00
2107	Томилолт, зочны зардал	29,436,000.00	71,735,288.20
210701	Гадаад албан томилолт	-	14,992,888.20
210702	Дотоод албан томилолт	29,436,000.00	56,742,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,329,295.00	20,617,897.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,270,955.00	12,020,897.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	7,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	249,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	204,240.00	257,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,583,000.00	1,340,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,551,857.28</b>	<b>14,043,799.05</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	14,043,799.05
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	14,043,799.05
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,043,799.05
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	14,043,799.05

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,551,857.28	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,551,857.28	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,999,000.00</b>	<b>-</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,999,000.00</b>	<b>2,306,848,919.11</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,999,000.00</b>	<b>2,306,848,919.11</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	4,999,000.00	2,306,848,919.11
220001	Барилга байгууламж	-	2,306,848,919.11
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,999,000.00	-
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(4,999,000.00)</b>	<b>(2,306,848,919.11)</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>-</b>	<b>2,306,848,919.11</b>
1451	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	2,306,848,919.11
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	2,306,848,919.11
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-</b>	<b>2,306,848,919.11</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Нэр, төрөл	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,106,492,229.39</b>	<b>5,106,492,229.39</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,106,492,229.39	5,106,492,229.39
9	Тайлант үеийн үр дүн	14,959,463,533.37	14,959,463,533.37
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,065,955,762.76</b>	<b>20,065,955,762.76</b>
13	эрхийлсэн үлдэгдэл	20,065,955,762.76	20,065,955,762.76
19	үеийн үр дүн	2,289,079,780.69	2,289,079,780.69
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>22,355,035,543.45</b>	<b>22,355,035,543.45</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>648,190,000.00</b>	<b>619,146,200.95</b>	<b>(29,043,799.05)</b>	<b>95.5</b>
12	Татварын бус орлого	648,190,000.00	619,146,200.95	(29,043,799.05)	95.5
122	Тусламжийн орлого	648,190,000.00	619,146,200.95	(29,043,799.05)	95.5
122005	Төсвөөс санхүүжих	648,190,000.00	619,146,200.95	(29,043,799.05)	95.5
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,955,190,000.00</b>	<b>2,925,995,120.06</b>	<b>(29,194,879.94)</b>	<b>99.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>648,190,000.00</b>	<b>619,146,200.95</b>	<b>(29,043,799.05)</b>	<b>95.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>648,190,000.00</b>	<b>619,146,200.95</b>	<b>(29,043,799.05)</b>	<b>95.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,300,000.00	416,220,322.42	(79,677.58)	100.0
210101	Үндсэн цалин	416,300,000.00	416,220,322.42	(79,677.58)	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,037,500.00	34,611,647.50	(17,425,852.50)	66.5
210201	Тэтгэврийн даатгал	34,585,500.00	21,500,534.62	(13,084,965.38)	62.2
210202	Тэтгэмжийн даатгал	4,163,000.00	4,162,203.22	(796.78)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,881,500.00	2,865,022.57	(16,477.43)	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	2,081,500.00	553,080.65	(1,528,419.35)	26.6
210205	Эрүүл мэндийн даатгал	8,326,000.00	5,530,806.44	(2,795,193.56)	66.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,000,000.00	45,960,000.00	(40,000.00)	99.9
210304	Байрны түрээс	46,000,000.00	45,960,000.00	(40,000.00)	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	23,790,000.00	22,201,817.83	(1,588,182.17)	93.3
210401	Бичиг хэрэг	2,680,000.00	2,637,500.00	(42,500.00)	98.4
210402	Тээвэр, шатахуун	18,150,000.00	16,965,200.00	(1,184,800.00)	93.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,000.00	900,517.83	(359,482.17)	71.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,700,000.00	1,698,600.00	(1,400.00)	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,800,000.00	7,799,228.00	(772.00)	100.0
210604	Урсгал засвар	7,800,000.00	7,799,228.00	(772.00)	100.0
2107	Томилолт, зочны зардал	72,412,500.00	71,735,288.20	(677,211.80)	99.1
210701	Гадаад албан томилолт	15,000,000.00	14,992,888.20	(7,111.80)	100.0
210702	Дотоод албан томилолт	57,412,500.00	56,742,400.00	(670,100.00)	98.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,850,000.00	20,617,897.00	(9,232,103.00)	69.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,780,000.00	12,020,897.00	(8,759,103.00)	57.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	720,000.00	257,000.00	(463,000.00)	35.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,340,000.00	(10,000.00)	99.3
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,307,000,000.00</b>	<b>2,306,848,919.11</b>	<b>(151,080.89)</b>	<b>100.0</b>
220001	Барилга байгууламж	2,307,000,000.00	2,306,848,919.11	(151,080.89)	100.0
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(2,307,000,000.00)</b>	<b>(2,306,848,919.11)</b>	<b>151,080.89</b>	<b>100.0</b>
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,307,000,000.00</b>	<b>2,306,848,919.11</b>	<b>(151,080.89)</b>	<b>100.0</b>
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
72	<b>ЗГ-ын зээл</b>	<b>2,307,000,000.00</b>	<b>2,306,848,919.11</b>	<b>(151,080.89)</b>	<b>100.0</b>
722	<b>Гадаад</b>	<b>2,307,000,000.00</b>	<b>2,306,848,919.11</b>	<b>(151,080.89)</b>	<b>100.0</b>
7221	Төслийн зээл	2,307,000,000.00	2,306,848,919.11	(151,080.89)	100.0
322101	Шинээр авах	2,307,000,000.00	2,306,848,919.11	(151,080.89)	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Усны нөөцийг хамгаалахад бодит хувь нэмэр оруулж, усны зүй зохистой хэрэглээг дэмжин, Дархан хотын усны алдагдлыг бууруулж, ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг сайжруулан хэрэглэгчдийг эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаат ус хангамжийн үйлчилгээгээр хангах нөхцөлийг бүрдүүлэх, Дархан хотын усны хэрэглээнд ухаалаг систем нэвтрүүлж, монголын анхны ухаалаг хэрэглээтэй цахим хот болгоход оршино. Төсөл хэрэгжсэнээр Дархан-Уул аймгийн цэвэр усны магистрал шугам сүлжээний зарим хэсэг шинэчлэгдэж, усны алдагдал буурах, хүн амын ус хангамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, усны ухаалаг хэрэглээг нэвтрүүлж, хэвшүүлэн, эдийн засгийн хэмнэлт бий болж иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна.

Төслийн зорилго: Усны нөөцийг хамгаалахад бодит хувь нэмэр оруулж, Дархан хотын усны алдагдлыг бууруулах, усны зүй зохистой хэрэглээг дэмжих, ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг сайжруулах хэрэглэгчдийг баталгаат ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээгээр хангах нөхцөлийг дээшлүүлэх Дархан хотын усны хэрэглээнд ухаалаг систем нэвтрүүлж, Монголын анхны ухаалаг хэрэглээтэй цахим хот болгоход оршино.

Төслийн зорилт:

- Төслийн техник, эдийн засгийн үнэлгээ, зуран төсөл боловсруулах, батлуулах;
- Батлагдсан зураг төслийн дагуу инженерийн шугам сүлжээний угсралт хийж ашиглалтад оруулах;
- Ухаалаг тоолуур суурилуулж нэвтрүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг явуулах;
- Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлсэн байна.

**Төслийн хүрэх үр дүн:**

- Дархан хотын инженерийн дэд бүтэц сайжран, усан хангамжийн насжилт өндөртэй 13.3 км шугам хоолойгоор шинэчлэгдэнэ;
- Усны зүй зохистой хэрэглээ бий болж, Дархан хотын усны алдагдал буурч, 15000 усны ухаалаг тоолуур суурилагдан, ухаалаг систем нэвтэрнэ;
- Инженер техникийн ажилчдын мэдлэг чадавх дээшилж, нийт хэрэглэгчдийн усны хэрэглээний боловсрол нэмэгдэнэ;

**Хүйтэн усны ухаалаг тоолуур LXSG-K, LXSG-R загварын алсын зайны ухаалаг тоолуур нэвтрүүлсний давуу талууд:**

- Монгол Улсад Стандартчилал хэмжил зүйн газрын баталгаажуулалт хийгдсэн цэвэр усны алсын зайн соронзон хамгаалалттай, ухаалаг тоолуур нэвтрүүлсэн туршлагатай байгууллагатай болсон.
- Logawan олон үйлдэлт антенаар 13 төрлийн мэдээллийг дамжуулна.
- Ухаалаг систем ашигласнаар усны зүй бус хэрэглээг гаднын нөлөөллөөс хамгаалж, алсын зайнаас удирдана.
- Байцаагчийн орон тоог хэмнэнэ.
- Усны алдагдал буурна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бүгд найрамдах Австри Улсын Экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн нэгжийг Сангийн сайдын 2023 оны 113 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог 6 байхаар баталсан байна.

Төслийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Сангийн яам, Барилга хот, байгуулалтын яам, хамтран хэрэгжүүлэгч Дархан-Уул аймгийн ЗДТГ, төсөл хэрэгжих хугацаа нь 2023-2025 он, төсөвт өртөг-7.5 сая евро, ерөнхий гүйцэтгэгч “Ти Ар Эм ХХК, туслан гүйцэтгэгч Эм Ти Юу ХХК байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 5 дугаар албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ны дөрийн 4 дүгээр тушаалын хавсралт Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах , эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ,зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам;
- 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 03дугаар сарын 21-ны өдрийн 139 тоот тушаал;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хот байгуулалт , барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 180 дугаар тушаалаар Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх АУС239 885 төслийн удирдах хороо шинэчлэн байгуулагдсан. Тус хороо нь тайлант онд 4 удаа хуралдаж 1 тогтоол 4 зөвлөмж гаргасан байна. Зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Сангийн яамны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, үнэлгээний газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх , шинэчлэх , ухаалаг тоолуур нэвтрүүлэр төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх , шинэчлэх , ухаалаг тоолуур нэвтрүүлэр төсөл 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,289,079.8 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	19,999,235.0	22,304,293.7	2,305,058.7
Үндсэн хөрөнгө	66,720.7	50,741.8	(15,978.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>20,065,955.7</b>	<b>22,355,035.5</b>	<b>2,289,079.8</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	20,065,955.7	22,355,035.5	2,289,079.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,065,955.7	22,355,035.5	2,289,079.8

- Бараа материал дансны үлдэгдэл оны эхнээс 2,305,058.7 мянган төгрөгөөр өссөн нь төслийн хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,978.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 430,164.3 мянган төгрөг, нийт зарлагыг 430,164.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсийг 132,314.0 мянган төгрөг, НДШ-ийг 16,539.2 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 10,247.5 мянган төгрөг, хангамжийн зардлыг 5,902.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 4,800.0 мянган төгрөг, албан томилолтын зардлыг 29,212.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний төлбөр хураамжийг 19,010.0 мянган төгрөг, нийт 218,025.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 648,190.0 мянган төгрөгөөр хянан баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 633,190.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 619,146.2 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 14,043.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 619,146.2 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 1,588.2 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 9,232.1 төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Бүгд найрамдах Австри улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын тооцоогоор тайлант онд нийт 592,174.6 еврогийн гүйлгээ хийгдэж, 2,306,848.9 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

**Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207-83112 гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	648,190.0	619,146.2	14,043.8	97.8
2	70207-80104 гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил	2,307,000.0	2,306,848.9	151.1	100.0
		<b>2,956,190.0</b>	<b>2,925,995.1</b>	<b>14,194.9</b>	

**Судалгааны үр дүн:**

- Бүгд найрамдах Австри Улсын экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалдаг тоолуур нэвтрүүлэх төслийн нэгжийг Сангийн сайдын 2023 оны 113 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог удирдах -1, гүйцэтгэх-5 байхаар тогтоосон ба гүйцэтгэлээр удирдах-1, гүйцэтгэх-5 нийт 6 орон тоогоор ажилласан байна.
- Гадаад томилот, арга хэмжээний зардалд 15,000.0 мянган төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 14,992.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Тайланд онд сургалт арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй, тайлант онд санхүүжүүлээгүй байна.
- Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Барилга хот байгуулалтын яамнаас 2022 онд зарласан ГЗ-АУХШС/БХБЯ-2022-01 дугаартай ажлыг 7,500.0 мянган еврогоор гүйцэтгэхээр тендерт шалгарсан Бүгд найрамдах Австри Улсын “Ти-Ар-Эм” ХХК төслийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төслийн үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, шилэн данс, үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Сождидмаа компанийн захирал С.Тунгалаг, анхан шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт зардлын 566,733.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,667.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 167 мэдээлэл байршуулахаас 167 мэдээлэл хугацаандаа байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж үзсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Санхүүгийн тайлангийн аудитаар завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төслийн түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээт ажлыг гүйцэтгэлийг дүгнэж, хүлээлцүүлсэн актыг дараагийн аудитаар хянан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,306,848.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 2,306,848.9 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Засгийн газрын гадаад төслийн зээлийн төрийн сан дахь 100900011648 дугаар харилцах дансны 2,306,848.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй.

Аудитаар нийт 2 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь, гүйцэтгэгч "Ти Ар Эм" компаниас төслийн 3 дахь шатны ажилд нийлүүлсэн 5.0 мянган ширхэг /1,643,750.0 мянган төгрөг/ ухаалаг тоолуурыг хүлээн авсан боловч, Сангийн яамнаас төлбөрийг шилжүүлээгүйгээс санхүүгийн тайланд бусад эргэлтийн хөрөнгийн дансанд орлогоор бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "13.2.Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар" заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг,нийцсэн бөгөөд зохистой байх ,иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

**Өгсөн зөвлөмж** Сангийн яамтай тооцоо нийлж, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлэх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **2. Төслийн гэрээний хэрэгжилтийн хугацаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 2024 онд дуусах 7.5 сая еврогийн AUS239885 тоот гэрээг нийт 3 удаа сунгасан бөгөөд 2025 оны 10 сарын 23-ны гэрээгээр 2026 оны 3 сарын 31-нд дуусгахаар заасан хугацаанд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийг гэрээний хугацаанд дуусгаж үргүй зардал гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засгийн газрын гадаад төслийн зээлийн төрийн сан дахь 100900011648 тоот харилцах дансны 2,306,848.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	1	2,306,848.9	1	2,206,848.9			1	2,206,848.9	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,306,848.9</b>	<b>1</b>	<b>2,206,848.9</b>			<b>1</b>	<b>2,206,848.9</b>	<b>-</b>	<b>-</b>		<b>-</b>

Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь, гүйцэтгэгч "Ти Ар Эм" компаниас төслийн 3 дахь шатны ажилд нийлүүлсэн 5.0 мянган ширхэг /1,643,750.0 мянган төгрөг/ ухаалаг тоолуурыг хүлээн авсан боловч, Сангийн яамнаас төлбөрийг шилжүүлээгүйгээс санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	
3	Тайлант онд Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 2024 онд дуусах 7.5 сая еврогийн AUS239885 тоот гэрээг нийт 3 удаа сунгасан бөгөөд 2025 оны 10 сарын 23-ны гэрээгээр 2026 оны 3 сарын 31-нд дуусгахаар заасан хугацаанд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-		
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>					<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>		